



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/108

Чингис хот

Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх,
зарим хязгаарлалтын арга хэмжээг авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт зорчигч тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 06:00 цагаас нээж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах болон зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга Цагдаагийн хурандаа Б.Батсайхан, Авто тээврийн төвийн дарга Б.Ганбат, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, Монгол цэргийн өдөр, Наурызын баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад үүрэг болгож хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун, Шуурхай штабын дарга дэд хурандаа Н.Чанцал нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

20200303